

1.5 Худалдан авалтын талаар

Тайлант хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д

Нээлттэй тендер шалгаруулалт-0

Харьцуулалтын аргаар-1

Бусад худалдан авалт-33 хийгдсэн байна.

Үүнд:

1. Харьцуулалтын аргаар хийгдсэн худалдан авалтын тухайд- “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2015 оны 12 сарын 07-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/62 тоот тушаалын дагуу ажлын хэсэг томилогдон албан хэрэгцээнд нэн шаардлагатай байгаа архивын нягтаршуулсан шүүгээ худалдан авах тендерийг харьцуулалтын аргаар ТБОНӨХБАҮХА хуулийн хүрээнд зохион байгуулсан байна. Энэ нь “Төрийн Өмчийн Хороо”-оос батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авсны үндсэн дээр хийгдсэн бөгөөд төсөвт өртгөөс хямд үнээр гүйцэтгэгдсэн. Мөн ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Үүнээс 2 гишүүн нь АЗ сертификаттай худалдан авалтын мэргэжилтэн, 3 нь бичиг хэргийн ажилтан болон бусад холбогдох ажилчид оролцон ажилласан байна. Ашиг сонирхлын зөрчилгүй худалдан авалт гэж үзэж байна.

№	Бараа, ажил үйлчилгээний нэр	Өртөг			Гүйцэтгэгч
		Төсвөөрх	Гэрээгээрх	Гүйцэтгэлээрх	
1	Архивын нягтаршуулсан шүүгээ	30,000	23,500	23,500	“Хиаглан” ХХК

2. Бусад жижиг үнийн дүн бүхий бараа материал бусад худалдан авалтаар **15,343** мянган төгрөгийн зарлага гарч ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1 д заасан босго үнийн дээд хязгаарыг баримталсан бөгөөд НББ-ын анхан шатны баримт бүрдүүлэлт бүрэн гэж дүгнэлээ.